

Сурагчийн ёс зүйн дүрэм

Сурагчид болон эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл.

NSW мужийн улсын сургуулиудад харьяалагдах сурагч бүр сурлагын хамгийн өндөр түвшинд хүрэхийг ямагт эрмэлзэнэ.

Энэхүү дүрмийг NSW мужийн улсын сургуулийн бүх сурагчид мөрдөх үүрэгтэй. Уг дүрмийг сургуулийн дотор болон гадуур, онлайн орчин зэрэг бүх үйл ажиллагаанд мөрдөгдөнө. Мөн сурагчид өөрсдөө болон бусад сурагчид, багш нар, сургуулийн ажилтнууд, олон нийтийн гишүүдтэй хэрхэн харилцах харилцааг уг дүрмээр зохицуулна.

Би багш болон ажилтнуудын заавар, чиглэлийг дагаж мөрдөхдөө **бусдад хүндэтгэлтэй, хариуцлагатай**, аюулгүй байж энэхүү дүрмийг мөрдөнө.

Бусдад хүндэтгэлтэй хандах

Энэ нь сурагч бүр өөрийгөө бусдаар хүлээн зөвшөөрөгдөж, хамрагдсан орчныг бий болгохын тулд тэдэнд харилцан хүндэтгэлтэй, ойлгож хандахыг хэлнэ.

Би дараах зүйлсийг мөрдлөг болгоно:

- анхаарал хүндэтгэлтэйгээр бусдыг сонсох, ярилцах
- суралцах явцдаа төвлөрөх боломжийг бусдад олгох
- бусдыг үнэлэн хүндэлж хамруулан хандах, мөн тэдэнд шударгаар хандах
- сургуулийн орчныг хайрлан хамгаалах
- сургуулийн дүрэмт хувцсыг зөв, бахархалтайгаар өмсөх.

Хариуцлагатай байх

Энэ нь сурагч бүр эв найрамдалтай байж сурлагадаа анхаарлаа хандуулахын тулд тухайн сурагч бүр анхаарал болгоомжтой байхыг хэлнэ.

Би дараах зүйлсийг мөрдлөг болгоно:

- өдөр бүр сургуульдаа ирж, хичээлдээ цагтаа оролцон, өөрт шаардлагатай зүйлсээ авчирч, суралцахад бэлэн байх
- сургуулийн болон ангийн дүрэм, дэг журмыг дагах
- технологийг аюулгүйгээр суралцах зорилгоор ашиглах
- даалгаврыг бүрэн гүйцэтгэж, өөрийн бүрэн чармайлтыг гаргаж, хэрэгтэй үед тусламж хүсэх
- боломжтой үедээ бусдад туслах
- өөрийн хийсэн алдаанаасаа суралцаж, өөрийгөө сайжруулахыг хичээх.

Аюулгүй байдлыг хангах

Энэ нь сурагч бүр сургуулийн орчинд аюулгүй байхын тулд өөрийгөө болон бусдыг анхааран хамгаалахыг хэлнэ.

Би дараах зүйлсийг мөрдлөг болгоно:

- багш болон сургуулийн ажилтнуудаас өгсөн зааврыг дагах
- бусдын орон зай, хувийн нууц болон эд зүйлсийг хүндэтгэх
- хэн нэгний аюулгүй байдал алдагдсан эсвэл хэн нэгэнд шударга бус хандсан тохиолдолд энэ талаар санал бодлоо илэрхийлж, тусламж хүсэх
- зөрчил, санал зөрөлдөөнийг тайван, шударгаар шийдвэрлэх.

Бусдын аюулгүй байдлыг алдагдуулахгүйн тулд би дараах үйлдлүүдийг хийх ёсгүй:

- бусдын хэн болох, юугаараа өөр болохоос нь хамааралтайгаар шударга бусаар хандах
- хүчирхийлэл үйлдэх, гэмтээх, сүрдүүлэх, дарамтлах, дээрэлхэх (үүнд утас, төхөөрөмж, компьютер, онлайн орчин болон сошиал медиа ашиглах хамаарна)
- сургуульд зэвсэг, хууль бус мансууруулах бодис, архи, вейп, цахилгаан тамхи эсвэл тамхи авчрах.

Хэрэв би эдгээр үйлдлүүдийг хийвэл сургуулийн зүгээс сурагч бүрийн аюулгүй байдлыг хангаж, суралцах боломжийг хангах зорилгоор арга хэмжээ авах ба үүнд сургуульд явах эрхийг түр хугацаагаар хасах арга хэмжээ багтаж болно.

Багш нар болон сургуулийн ажилтнууд миний суралцах, зөв шийдвэр гаргах, мөн аюулгүй байхад тусалдаг. Би энэхүү дүрмийг мөрдөж, бусдад дэмжлэг үзүүлж, тэдний эрхэнд хүндэтгэлтэйгээр хандана. Мөн өөрийн сургуулийг суралцах тав тухтай орчин байлгахын тулд өөрийн санаа бодлоо бусадтай хуваалцана.

Би Сурагчийн ёс зүйн дүрмийг хүлээн авснаа баталгаажуулж, уг дүрэмд тусгагдсан шаардлага, хүлээлтүүдийг хүлээн зөвшөөрч байна.

Сурагчийн нэр:

Би / бид Сурагчийн ёс зүйн дүрмийг хүлээн авснаа баталгаажуулж, уг дүрэмд тусгагдсан шаардлага, хүлээлтүүдийг хүлээн зөвшөөрч байна.

Эцэг эх/асран хамгаалагчийн нэр:

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг:

Утасны орчуулагчийн үйлчилгээ

Хэрэв та илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захиралтай холбогдоно уу. Хэрэв танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол 131 450 дугаарт залгаж, өөрийн хэл дээр орчуулагч авах хүсэлт гаргана уу.

Операторт холбогдохыг хүсэж буй утасны дугаараа хэлэхэд, оператор танд ярианд туслах орчуулагчийг холбож өгнө. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй.